



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар

11206

Улаанбаатар хот

Налайх дүүргийн “Гэрэлтүүлэг чимэглэлийн алба” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 80,712,840.00 (наян сая долоон зуун арван хоёр мянга найман зуун дөч) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Налайх дүүргийн “Гэрэлтүүлэг чимэглэлийн алба” ОНӨААТҮГ (Г.Баярсүрэн)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 23 нэр төрлийн 51,017,820.00 (тавин нэгэн сая арван долоон мянга найман зуун хорь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 2 нэр төрлийн 29,695,020.00 (хорин есөн сая зургаан зуун ерэн таван мянга хорь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 450,000.00 (дөрвөн зуун тавин мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь 135,000.00 (нэг зуун гучин таван мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн Төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэн, Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийхийг Налайх дүүргийн “Гэрэлтүүлэг чимэглэлийн алба” ОНӨААТҮГ (Г.Баярсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500758

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2024 оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_ -ны өдрийн  
\_\_\_\_\_ дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Гэрэлтүүлэг чимэглэлийн алба

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХТ-ын мөргөжлтийн дүгнэлт	УХХК-н шийдвэр
1	Hikvision гадаа камер 7-р хороо Бадралын 3-н 27,28	5	ш	2	930,000	1,860,000	1,860,000	-	эвдэрсэн засварлах боломжгүй	Устгах	Устгах	Устгах	Устгах
2	Hikvision эргэдэг камер 7-р хороо Бадралын 7-р гудамж	5	ш	1	930,000	930,000	930,000	-	эвдэрсэн засварлах боломжгүй	Устгах	Устгах	Устгах	Устгах
3	Hokvision гадаа камер 7-р хороо Шинэ Налайх ЦХ	5	ш	4	930,000	3,720,000	3,720,000	-	эвдэрсэн засварлах боломжгүй	Устгах	Устгах	Устгах	Устгах
4	Hikvision гадаа камер 7-р хороо Өвөршандын /8а, 9а, 11-6, 13-1, 17, 18, /19,	5	ш	8	918,500	7,348,000	7,348,000	-	эвдэрсэн засварлах боломжгүй	Устгах	Устгах	Устгах	Устгах
5	Hikvision эргэдэг камер 7-р хороо Өвөршандын /21, тойрог, ХЗХТөв/	5	м	2	918,500	1,837,000	1,837,000	-	эвдэрсэн засварлах боломжгүй	Устгах	Устгах	Устгах	Устгах
6	Hikvision гадаа камер 4-р хороо туулын хэсгийн камер	5	м	10	938,500	9,385,000	9,385,000	-	эвдэрсэн засварлах боломжгүй	Устгах	Устгах	Устгах	Устгах
7	Hikvision гадаа камер 4-р хороо туулын / их ам, 3,26,19,1,12, алтайн-1,5,4, /	5	ш	10	930,000	9,300,000	9,300,000	-	эвдэрсэн засварлах боломжгүй	Устгах	Устгах	Устгах	Устгах
8	Бичлэг хадгалах төхөөрөмж 5-р хороо Дэлгэц хяналтын 32" 5-р хороо	6	ш	1	700,000	700,000	700,000	-	зардлаа нөхсөн ашиглахгүй байгаа	Устгах	Устгах	Устгах	Устгах
9	Камер дугаар хардаг - 2018 1-р хороо	6	ш	1	550,000	550,000	550,000	-	ашиглах боломжгүй	Устгах	Устгах	Устгах	Устгах
10	Камер дугаар хардаг - 2018 1-р хороо	6	ш	1	1,185,020	1,185,020	1,185,020	-	ашиглах боломжгүй	Устгах	Устгах	Устгах	Устгах

